



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/604

Булган сум

Шадүвдандар аграмбын мэндэлсний
190 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний
хурлын үйл ажиллагаанд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025 оны “Засаг даргын нөөц хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгоход баримлах журам” батлах тухай А/377 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын буддын гүн ухааны нэрт төлөөлөгч Шадүвдандар аграмбын мэндэлсний 190 жилийн ойд зориулсан “Шадүвдандар аграмба–190 Намтар, зохиол бүтээлийн судалгаа” эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Арга хэмжээнд шаардлагатай 4,950,360 (дөрвөн сая есөн зуун тавин мянга гурван зуун жаран) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
09 дүгээр сарын 24-ний өдрийн
А/60 дугаар захирамжийн хавсралт

“Шадүвдандар аграмба–190 Намтар, зохиол бүтээлийн судалгаа”
эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагаанд шаардагдах төсөв

д/д	Зориулалт	Хэмжих нэгж	Үнэ	Нийт
1	2	3	4	5
1	Айраг	200 л	8000	1,600,000
2	Шатахууны зардал	341 л	3960	1,350,360
3	Дэмжлэг			2,000,000
4	Нийт			4,950,360